



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-5
1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, эцэслэн батлах/	4-5

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 23-ны өдөр /Мягмар гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 69 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 27 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Амгаланбаатар, Д.Батбаяр, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баясгалан, Б.Бейсен, А.Ганбаатар, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Д.Жаргалсайхан, Л.Мөнхбаатар, П.Мөнхтулга, Ц.Туваан, Б.Түвшин, Л.Энхнасан, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Х.Баттулга, П.Батчимэг, С.Зулпхар, М.Нарантуяа-Нара, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пунсалмаа, Ч.Ундрэм, Ө.Шижир, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Баатархүү, Д.Батлут, Х.Болормаа, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Д.Ганбат, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, С.Лүндэг, Б.Мөнхсоёл, Г.Тэмүүлэн;

Тасалсан: Ж.Батсуурь, С.Ганбаатар, Г.Дамдинням, Б.Жавхлан, М.Мандхай, З.Мэндсайхан, П.Наранбаяр, Ж.Энхбаяр, Д.Энхтуяа, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан -15 минут, Н.Алтанхуяг -22 минут, Н.Алтаншагай -08 минут, О.Батнайрамдал -05 минут, Э.Батшугар -10 минут, Ж.Золжаргал -11 минут, Ч.Номин -08 минут, П.Сайнзориг -04 минут, Ц.Сандаг-Очир -01 минут.

Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, эцэслэн батлах/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан нар байлцав.

Н.Учрал: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 12

Бүгд: 78

Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар буюу 84.6 хувиар хууль батлагдлаа.

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6-д заасны дагуу хуулийн эцсийн найруулгыг сонсох санал гаргав.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./14:55/

Уг асуудлыг 14 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн референт Б.Нарантуяа, шинжээч С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 29 минут үргэлжилж, 126 гишүүнээс 78 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 56 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 27 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж мэндчилье. 69 гишүүн ирж, 54,8 хувийн ирцтэй байна. Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ. 1 дүгээрт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална. Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулж боловсруулсан хуулийн төсөл байгаа. Гишүүд асуулт асууж, хариултаа авч дууссан. Мөн 2 дугаар асуудлаар Парламентын бүлгэмийн даргыг, Парламентын бүлгэмийн даргын асуудал байгаа.

Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо энэ цаг мөчид хуралдаад, хэлэлцэх асуудал дуусаагүй байна. Тэгэхээр 2 Байнгын хороо түр завсарлаад, чуулган дээр санал хураалтад орчхоод үргэлжлүүлэх саналтай байна. Тамгын газраас энэ Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж даргад, Төсвийн байнгын хорооны дарга Наранбаатар дарга нарт хэлээд, түр завсарлаад, санал хураалтыг явуулчихъя, тэгээд үргэлжлүүлээд Байнгын хороогоо хуралдуулах саналтай байна.

Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооны гишүүдийг танхимд урьж байна. Түр завсарлуулчихмаар байна. Төсөв, Эдийн засгийн байнгын хороо руу очоод яриадхаач. Энэ хэлэлцэх асуудал нь дуусдаггүй. Хэлэлцэх асуудалд оръё.

Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, эцэслэн батлах/

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална. Хуулийн төслийн эцэслэн батлуулах хувилбарыг Хууль зүйн байнгын хороо бэлтгээд, гишүүдэд тараасан байна. 2 Байнгын хорооны гишүүдэд талархаж байна. 1 санал хураалт л явуулна. Энэ бас цаг хугацаатай асуудал байгаа учраас өнөөдөр эцэслэн батлах шаардлагатай байна. Гишүүд асуулт асууж, хариултаа авч дууссан. Тийм, Цэцийн шийдвэртэй холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална. Хууль зүйн байнгын хорооны бэлтгэсэн саналыг гишүүдэд тараасан байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Төсвийн байнгын хорооны гишүүдийг танхимд урьж байна. 1 л санал хураалт явуулна. Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудал өндөрлөөгүй байгаа тул гишүүд танхимд бүрэн цуглаагүй байна. Төсвийн байнгын хороог түр завсарлуулаад, санал хураалтад оръё. Гишүүд санал хураалтад бэлтгэе. 74 гишүүн уншуулчихсан байна. Төсвийн байнгын хорооноос гишүүд орж ирсэн үү? Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлтгэе.

Ардчилсан намын бүлэг, Ардчилсан намын бүлэг цугламаар байна. Өнөөдөр Батжаргал даргатай Ардын намын бүлэг онцгой сайн байна шүү. Ардчилсан намын бүлэг бас цуглая. ХҮН нам дуудаарай. Энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл цаг хугацаатай асуудал. Цэцийн дүгнэлт гарсантай холбогдуулаад нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа төсөл. Гишүүд анхааралтай бүртгэлийн санал хураалт хийгээдэхье, гишүүд анхааралтай бүртгэлийн санал хураалт явуулах гэж байна. Тэгээд үргэлжлээд Эдийн засаг, Төсөв 2 хуралдана. Цаг хугацаа бага байна. Бүртгэлийн санал хураалт. Гишүүд санал хураалтад бэлтгээд, бүртгэлийн санал хураалт. Бямбацогт дарга дарж чадсангүй. Одоо шууд санал хураалтыг явуулъя.

Хуулийн төслийн эцэслэн батлуулах хувилбарыг Хууль зүйн байнгын хороо гишүүдэд тараасан байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт. 66 гишүүн дэмжиж, 84,6 хувиар санал дэмжигдлээ. Хуулийн төслийг эцэслэн баталлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал илэрхийлье. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гишүүн горимын санал хэлнэ.

Д.Цогтбаатар: Их Хурлын даргаа энд одоо энэ хуультай холбогдуулаад Дэгийн хуулийн 44.6-д заасны дагуу хуулийн эцсийн найруулгыг шууд хамт сонсоод явчихъя гэсэн санал гаргаж байна.

Н.Учрал: Хууль зүйн байнгын хорооны даргын гаргасан саналын дагуу баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

14.55 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА